

ТҮШИГ УУЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Санхүүгийн болон үйл ажиллагааны Г

тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.5 дахь заалтууд болон “ТҮШИГ УУЛ” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ТҮШИГ УУЛ” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай хэмээн үзсүгэй. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагаа зогсонги байдалтай хэвээр үргэлжилж, алдагдалтай ажилласантай холбогдон ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. 2018 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, ашигтай ажиллах талаар идэвхи санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Батсайхан/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/ Ж.БАЯРАА /

**“ТҮШИГ УУЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

┌ Компанийн ТУЗ-ийн гишүүдийг ┐

томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтууд болон “ТҮШИГ УУЛ” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ж.Баяраа
2. Ж.Баянтөр
3. Ж.Баянцогт
4. Л.Ганчимэг
5. Б.Үүрийнцолмон
6. Б.Бямбадорж

Хоёр. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Д.Батгэрэл
2. Ж.Бат-Амгалан
3. Д.Баттулга

Гурав. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ж.БАЯРАА/